

**БНМАУ-ын 1924, 1940, 1960 оны Үндсэн хууль:
Улс орны эдийн засгийн хөгжил, чиг хандлага**

**Constitutions of The Mongolian People's Republic
Ratified in 1924, 1940 and 1960 as the Determiners
of State Economy Development and its Tendency**

Борын Пунсалдулам

Доктор (Sc.D), профессор

*Шинжлэх Ухааны Академийн Түүх, угсаатны зүйн хүрээлэнгийн
Эрдэм шинжилгээний тэргүүлэх ажилтан*

Улаанбаатар хот, Монгол Улс

borpunsaal@gmail.com

© B.Punsaldulam, 2025



[Attribution-NonCommercial 4.0 International
\(CC BY-NC 4.0\)](https://creativecommons.org/licenses/by-nc/4.0/)

[Товч утга]

Олон мянган жил нүүдлийн мал аж ахуй голлон эрхэлж ирсэн монголчуудын аж байдал XIX зууны эцсээс өөрчлөгдөн аж хуйн шинэ хэвшлүүд үүсэн бий болж байв. Монгол орон дэлхийн зах зээлд мал, малын гаралтай түүхий эд, болон байгалийн баялгаараа татагдан орохын хамт малчин ардын дотор хөрөнгө чинээний байдлын ялгаа улам бүр нэмэгдэж байв.

Монголчууд уламжлалт аж ахуй, мал сүргээ адуулахын зэрэгцээ жин тээх, газар, мал (хөсөг уналгын) түрээслэх, хадлан эрхлэх, мөнгө хүүлэх болсон байна. Эдгээр нь аж ахуйн хүрээнд шинэ хэлбэр үүсгэж, түүнийг эрхлэх хөтлөх хүмүүсийг бий болгож, улмаар зах зээлийн харилцаа тэрлэн хөгжиж байв.

XX зууны эхээр төрийн тусгаар тогтнолоо зарлан тунхагласан Монголын төрөөс улс орноо орчин цагийн соёл боловсрол, аж үйлдвэр хөгжсөн дэлхийн улс орнуудын адил хөгжүүлэх бодлогыг тууштай баримтлан, хөгжүүлэхийг эрмэлзэн 1924, 1940 оны Үндсэн хуулиуд эдийн засаг дахь өмчийн олон хэлбэрийг хүлээн зөвшөөрч байв.

1960 онд батлагдсан Үндсэн хууль тус улсын эдийн засгийн харилцаанд улсын болон хоршооллын өмчийн хэлбэрийг батлан, улс ардын аж ахуйг нэгдсэн төлөвлөгөөтэй хөгжүүлэх хууль эрх зүйн үндсийг баталгаажуулжээ.

[Түлхүүр үг]

Эдийн засаг, шинэ хэлбэр, төлөвлөгөө, удирдлага, хөдөө аж ахуй, хөгжил.

I. Эхлэл

XIX зуунаас Монгол орон дэлхийн зах зээлд мал, малын гаралтай түүхий эд, болон байгалийн баялгаараа татагдан орохын хамт малчин ардын дотор хөрөнгө чинээний байдлын ялгаа улам бүр нэмэгдэж байв. Монголчууд уламжлалт аж ахуй, мал сүргээ адуулахын зэрэгцээ жин тээх, газар, мал (хөсөг уналгын) түрээслэх, хадлан эрхлэх, мөнгө хүүлэх болсон байна. Эдгээр нь аж ахуйн хүрээнд шинэ хэлбэр үүсгэж, түүнийг эрхлэх хөтлөх хүмүүсийн бүлэг бий болж, улмаар зах зээлийн харилцаа тэрлэн хөгжих үндсийг бүрдүүлжээ.

Үүний үр дүнд XX зууны эхээр Өргөө, Улиастай, Ховд, Хиагт, Вангийн хүрээ, Сан бэйсийн хүрээ зэрэг тус улсыг гадаад ертөнцтэй холбосон аян жингийн зам, түүний дагуу хот суурин үүсэж, тэдгээрийн улс орны эдийн засагт гүйцэтгэх үүрэг өсөн нэмэгдэх болсноор үндэсний нэгдсэн зах зээл үүсэн бүрэлдэх эхлэл тавигджээ. Эдгээр томоохон хот суурин газарт зах зээл, таваар мөнгөний харилцаа бусад газруудтай харьцуулбал, харьцангуй түргэн хөгжиж, сүм хийд, байшин барилга, байгуулалтын хэмжээ, оршин суугчдын тоо өсөн нэмэгдэж, хотын хүн амын хөдөлмөрийн хуваарь нарийсаж, нийгэм, ахуй, үйлчилгээний чиглэлийн аж ахуй эрхлэх болжээ. Ийнхүү дурдан буй үеийн Монгол оронд 140 мянган хүн хот суурин газарт оршин сууж байсан хэмээн И.М. Майский тооцоолжээ¹. Ч.Нямбуу хувьсгалын өмнө 20 орчим хот маягийн суурин байсан хэмээн тэмдэглэсэн байна².

Ийнхүү монголын уламжлалт нүүдлийн мал аж ахуйн хүрээнд аж ахуйн шинэ хэвшлүүд үүсэж байх үед Их Хүрээнд Үндэсний эрх чөлөөний хувьсгал ялж, Монгол төрийн тусгаар тогтнолыг сэргээн мандуулж, улс орны эдийн засгийн хөгжлийг өөд татан, дэлхий нийтийн хөгжлийн чиг хандлагын дагуу хөгжүүлэх чин эрмэлзэл дүүрэн байв. Сэргэн мандсан Монгол Улсын Засгийн газар улс орныхоо зах зээлийг нээлттэй байлгах, санхүүгийн албыг шинээр байгуулах, уламжлалт мал аж ахуй, тариаланг хөгжүүлэх, шинэ аж ахуйн салбаруудыг хөгжүүлэх, гэрээ, түрээсийн үйл ажиллагааг хянан тогтворжуулахад чиглэсэн дүрэм хэмжээ, журмуудыг гаргаж байв.

1921 оны Үндэсний ардчилсан хувьсгалын үр дүнд тогтсон Ардын Түр Засгийн газар үүсэн байгуулагдсан цагаасаа улс орны хөгжлийн үндэс суурь болох эдийн засгийг сэргээж, үндэсний аж үйлдвэр, худалдаа, зам тээвэр, шуудан холбоог хөгжүүлэхэд онцгой анхаарал тавьж байв. Тухайлбал, 1921 оны 5 дугаар сарын 21-нд

¹ И.М.Майский, Орчин үеийн Монгол, Улаанбаатар, 1999, 10 дахь тал

² Ч.Нямбуу, БНМАУ-ын хүн амын нөхөн үйлдвэрлэл, Улаанбаатар, 1967, 35 дахь тал

хуралдсан Монгол ард улсын хэмжээт цаазат ардын засгийн эрхлэх товчооны гишүүд хуралдаж “Газрыг хувийн өмч болгохыг устгасан тухай” зөвлөлдөн тогтоосон 19-р хурлын тогтоолд Нэг. Монгол ардын үндсэн хөрөнгө болох газрыг энгийн хүмүүст хувь хязгааргүй хэрэглүүлэх явдлыг устгавал зохино” хэмээн заажээ³.

Мөн 1921 оны 7 дугаар сарын 9 өдөр хуралдсан Монгол Ардын Засгийн хэргийг түр захиран шийтгэх тэргүүлэгчдийн хуралдсан 2 дугаар хурлын тогтоолд: “Төмөр утас телефоны хороо, утасгүй цахилгаан мэдээний хороод зэрэг газрыг Маславыг томилж захируулахаар тогтсон тул Маслав чиний бие, тушаалыг дагаж, эл дааж захирах нэр бүхий албаны хараа дансыг байцаан үзэж, нэн даруй манай Засгийн Газар мэдүүлэн ирүүлээд болгосугай. Үүнийг Маславт мэдэгдэн тушаагаад, хүрмэгц албан хэргийг хүлээн автугай гэж тушаахаар тогтов” хэмээн харилцаа холбоог улсын мэдэлд авах, өртөөний өрхүүдийг хасах, өртөөний дүрэм хэмжээ, хэвлэлийн хороо байгуулах, цахилгаан гэрлийг дэлгэрүүлэх тухай, санхүүг зузаатгах тухай, хоршоог байгуулах, улсын сангийн малыг үржүүлэх дүрэм, банк байгуулах тухай⁴ зэргээр аж ахуй, эдийн засгийн хөгжлийн чиглэлээр олон тогтоол шийдвэрүүд гарчээ.

1923 оны 3 дугаар сарын 1-нд Нийслэл Хүрээнд буй намын гишүүдийн хурлаар анх Цэвээн Жамсранов улс төрд эдийн засгийн холбогдсон нь сэдвээр илтгэл хэлэлцүүлж улмаар “Эдийн засгийн үндсэн бодлого”-ыг боловсруулах комисс байгуулжээ. Комиссын гишүүдэд Цэвээн Жамсрано, Цэрэндорж, Жамъян, Гомбожав, Баяндэлгэр нарыг томилж, комиссын тэргүүлэгчээр Жамъянг тавьж, уг хэргийг нэгэн сарын дотор гүйцэтгүүлэхээр тогтоожээ. Уг комиссоос эдийн засгийн бодлогыг төлөвлөн хэлэлцээд, 18 зүйлийн санал, бодлогыг Намын Төв Хорооноос хэвлүүлж, олон нийтэд тараахаар тогтоожээ.

Эдийн засгийн бодлогын баримт бичигт, автономитын үед байсан 13 сая малыг өсгөх, мал маллагааны арга ажиллагааг сайжруулах, байгалийн гамшгаас хамгаалах, элдэв өвчнөөс салгах, хашаа хороо, бууц, өвс тэжээлийг бэлтгэх зэрэг ажлыг хийх, буудай, арвай, сульхир, төмс зэрэг тариа ногоо тариалах, газар боловсруулах анжис, үр цацах цацуул, тариа хадах хадуур машин, сүү, тос цохих машин, боловсон усан тээрэм зэргээр тэтгэх, түүхий эдийг боловсруулах уурхайн үйлдвэр, малын гаралтай түүхий эдийг боловсруулах үйлдвэр байгуулах зэргээр нарийвчлан заажээ.

³ Монголын хууль тогтоомжийн түүхэн эмхтгэл, Хоёрдугаар боть 1911-1926, V сар, Улаанбаатар, 2010, 360 дахь тал

⁴ Монголын хууль тогтоомжийн түүхэн эмхтгэл, Хоёрдугаар боть 1911-1926, V сар, Улаанбаатар, 2010, 363-395 дахь тал

Эдийн засгийн бодлогыг амьдралд хэрэгжүүлэх алхмыг бодитой болгоход чиглэсэн дүрэм, журам гарган эрх зүйн орчныг бүрдүүлэхэд Ардын Засгийн Газар анхаарч, тариалангийн дүрэм, уурхайн дүрэм, хэмжүүрийн дүрэм, мал эмнэлгийн газрыг байгуулах ба бичиг дүрэм зэрэг олон журмыг баталжээ. Мөн Монголын худалдаа ба аж үйлдвэрийн банк байгуулахаар Зөвлөлийн Засагт нийгэм журамт бүгд найрамдах холбоот улстай Монгол улс тусгай тогтоосон гэрээ бичиг⁵ байгуулан ажиллаж байв.

1924 онд батлагдсан БНМАУ-ын анхдугаар Үндсэн хуульд дэлхийн улс орны эдийн засаг, нийгмийн хөгжлийн чиг баримжааг нэгдүгээр бүлгийн 14 дүгээр зүйлд: Бүх дэлхийн жинхэнэ ард түмний зорилго нь одоогийн эзэрхэг хөрөнгөтний байдлыг үндсээр нь устгаж, нийгэм журам ба эв хамт ёс журмыг эрмэлзэх тул бидний жинхэнэ ард улсаас гадаадтай харилцах засгийн бодлогыг бүх дэлхийн бага буурай улс ба хувьсгалт ард түмний ашиг тус, үндсэн зорилготой нийлүүлэн явуулбал зохино хэмээн ерөнхий байдлаар тусгажээ. Энд буй “эзэрхэг хөрөнгөтний байдал” гэдэг нь монопольд капитализмыг, “нийгэм журам” хэмээх нь зах зээлийн харилцааг, “эв хамт ёс журам”-ыг эрмэлзэх гэдэг нь эв хамтын зарчим буюу коммунист нийгмийг байгуулахыг эрмэлзэж байгааг тусгасан байна.

Монголчууд XIX зууны эцсээс дэлхийн зах зээлийн хөгжилд татагдан орж, улмаар төрийн тусгаар тогтнолоо сэргээн тунхаглаж, улс орноо орчин цагийн боловсрол, соёл, аж үйлдвэр хөгжсөн дэлхийн улс орнуудын адил хөгжүүлэхийг эрмэлзэж байсан тул XX зууны 20-оод оноос 1940 оны утга зохиол, ном бүтээлд нийгэм журам хэмээх үг олонтоо таардаг нь дээрхийн дагуу ойлгож, хүлээн авч байсантай холбоотой байв.

Харин анхдугаар Үндсэн хууль батлагдсанаас хойш Монгол орны нийгэм, улс төрийн амьдралд марксизм, ленинизмийн үзэл санааг дэлгэрүүлэх хэрэгт коминтерн, ЗХУКН онцгой анхаарч, тусалж, зөвлөгөө өгч, коминтерний бие төлөөлөгч болон зөвлөлтийн сургагч нарыг МАХН-ын Төв Хорооны дэргэд суулгаж, үзэл суртлын ажлыг өргөжүүлж байв. Нам, төр, нийгэм, соёл, боловсрол, аж ахуйн ажилтан сэхээтнүүд, эвлэлийн гишүүдийг сургах марксист дугуйлан, секцэд суулгах, түүнд зориулан хөтөлбөр, гарын авлага, материалыг олноор хэвлүүлэх болжээ.

МАХН боловсон хүчнийг бэлтгэх түр сургуулийг 1925 оноос өөрчилж, намын Төв хорооны харьяа Төв сургууль болгон өргөтгөн байгуулж, марксист онол, сургаалыг судлах болжээ.

⁵ Монголын хууль тогтоомжийн түүхэн эмхтгэл, Хоёрдугаар боть 1911-1926, V сар, Улаанбаатар, 2010, 476 дахь тал

Төгсөгч, суралцагчдаасаа шилж сонгон Москва дахь Дорно Дахины хөдөлмөрчдийн коммунист их сургуульд суралцуулан, марксизм-ленинизмын онол үндсийг зааж сургах боловсон хүчнийг бэлтгэхэд анхаарч, олон залуусыг сургажээ. 1930-аад оноос материалист диалектикийг “Бодисыг баримтлан шалгах ухааны эрдэм” нэртэйгээр анхлан зааж эхэлжээ. 1935 оноос нам, улсын ажилтны хоёр жилийн түр сургуульд “Лениний сургаал”, “Махбодыг хоёрдуулан зөрчлийг мэдэх ухаан” нэртэй материалист диалектикийг заах болжээ.

Аймаг сумдад улс төрийн дугуйлан, намын гэгээрлийн хурал, түр сургууль, курс, дугуйлан, семинар, лекцээр марксизм-ленинизмын үзэл санааг эрчтэй сурталчлах болжээ. 1938 оноос 1939 онд намын гэгээрлийн системээр намын доод, дээд хоёр шатны дугуйлан байгуулж, түүнд “Монгол эх орон” хэмээх ном ба “ЗХУ-ын эв хамт (большевикуудын) намын түүхийг судалж байв. 1939 онд хот, аймгийн төвүүдэд намын дээд, доод дугуйлан байгуулагдан 2000 гаруй хүн суралцсан бөгөөд сумдын түр сургууль 300 гаруй байгуулагдаж 4000 гаруй хүн суралцжээ⁶.

1925 оноос Маркс, Энгельс, Лениний зохиолоос орчуулах ажил хүчтэй өрнөжээ. Үүнтэй зэрэгцэн сүм хийд, лам нарын талаар дэс дараатай арга хэмжээг хэрэгжүүлэн, улс төр, эдийн засгийн үндэс суурийг бүрмөсөн устгаж, шашингүйн үзэл хүчтэй дэлгэрч байв. Марксизм, ленинизмыг Монголд дэлгэрүүлэх үзэл суртлын ажил нь тус улсад орчин цагийн боловсрол, шинжлэх ухааныг түгээн дэлгэрүүлэх, соён гэгээрүүлэх ажилтай зэрэгцэн явагдаж байсан тул түүний мөн чанар ил тод харагдахгүй далд байв.

Анхдугаар Үндсэн хуульд туссан “нийгэм журам” хэмээх нэр томъёог коминтерн болон большевик намын үзэл суртал, ухуулга, сурталчилгааны аргаар энэ нь тус улсад байсан эзэрхэг түрэмгий феодалын дарлалыг устгах нэгэн шат байсан, яг жинхэнэ “нийгэм журам” (анхдугаар Үндсэн хуульд “нийгэм журмыг монголчууд эв хамт ёстой зэрэгцүүлэн өөр утгаар ойлгож байсан) бол “эв хамт ёс журам” бөгөөд түүнд хүрэхийн тулд “хөрөнгөтний бус замаар” хөгжүүлэх явдал мөн хэмээн сурталчилж, зааварчилж, ойлгуулж эхэлжээ. Улмаар ном бүтээл дэх “Нийгэм журам” хэмээх үг 1940 оны Үндсэн хуулиас хойш бараг үзэгдэхээ больж, хөрөнгөтний бус хөгжлийн зам хэмээх үг ихэд дэлгэрчээ.

1940 оны БНМАУ-ын Үндсэн хуулийн Нийгмийн байгуулалт нэгдүгээр бүлгийн 1 дүгээр зүйлд: БНМАУ бол эзэрхэг түрэмгийг ба феодалын дарлалыг устгасан цаашид нийгэм журамд давшин орохын

⁶ Монголын нийгэм-улс төрийн сэтгэлгээнийн түүхийн асуудал (Философийн ухааны доктор, профессор Дуламын Дашжамцын мэндэлсний 85 жилийн ойд зориулав), Улаанбаатар, 2015, 142 дахь тал

учир улс орноо хөрөнгөтний бус замаар хөгжүүлэх явдлыг хангаж бүхий хөдөлмөрчин (малчин, ажилчин, оюутан) ардын тусгаар тогтносон улс мөн болно” хэмээн зааж анхдугаар үндсэн хуульд туссан агуулгаас өөрөөр тусгажээ.

1940 оны Үндсэн хуульд тусгасан хөрөнгөтний бус хөгжлийн зам хэмээх томьёоллын онол, арга зүйн үндсийг батжуулахын тулд намын гишүүдийн марксист ленинист боловсролыг дээшлүүлэх, намын гэгээрлийн системийг өргөтгөж, 1946 оноос улс төрийн боловсролын системээр намын гишүүдэд олгож диалектик, түүхийн материализмыг, 1947 оноос улс төрийн эдийн засгийн ухааныг системтэй олгох болжээ. 1947 оноос эхлэн “Суртал нэвтрүүлэгч” сэтгүүлийг гаргах болж, Марксист Ленинист онол, улс төр, эдийн засгийн өгүүллүүдийг нийтлэх болжээ. Марксизм Ленинизмын эх зохиолуудыг орчуулан хэвлэх ажлыг өргөтгөж, 1950 онд Намын Төв Хорооны дэргэд марксизм, ленинизмын сонгодог зохиолыг орчуулах редакцыг байгуулжээ. Мөн ондоо Улаанбаатар хотын намын хорооны дэргэд марксизм ленинизмын оройн их сургуулийг нээжээ.

Дээрх хөрөнгөтний бус хөгжлийн зам хэмээх томьёоллын онол, арга зүйн үндсийг бий болгох ажилд Намын Төв Хорооны дэргэдэх Намын түүхийн институт, Намын дээд сургууль, ШУХ-ийн философи, социологи, эрхийн хүрээлэн, Их, дээд сургуулиудын нийгмийн ухааны тэнхимийн эрдэмтэн судлаачид идэвхийлэн ажиллажээ. Хөрөнгөтний бус хөгжлийн зам, түүний зүй тогтол, нийгмийн анги давхраа, бие хүний оюун санаа, коммунист хүмүүжлийн систем, түүний бүтэц, социалист аж төрөх ёсны гол шинжүүдийг боловсруулан зааж өгсөн олон арван бүтээлүүдийг гаргажээ. Энэ асуудлыг боловсруулах зорилгоор онол практикийн хурлыг зохион байгуулж, хурлын материалыг эмхэтгэн гаргаж олон түмний хүртээл болгож байв.⁷

1970 онд МАХН-ын ТХ-ны УТТ-ны “МАХН-ын ТХ-ны дэргэдэх намын дээд сургуулийн талаар авах зарим арга хэмжээний тухай” №157 тоот тогтоол гарч “Намын түүхийн институт, Намын дээд сургуулийн хамтарсан эрдмийн зөвлөлийг байгуулж, МАХН-ын түүх, МАХН-ын зохион байгуулалт, онол практикийн асуудлаар эрдмийн зэрэг горилогчдоос шалгалт авч, хамгаалуулах ажлыг эхлүүлжээ. Энэ нь тус улсад ямар ч шинжлэх ухааны салбараар эрдмийн зэрэг хамгаалахын тулд эхлээд дээрх №157 тогтоолын дагуу заасан сэдвүүдээр шалгалт өгч, давж гарсны дараа эрдмийн зэрэг хамгаалах эрхээ олж авах болжээ. Түүнчлэн дээрх тогтоолоор МАХН-ын намын түүх, удирдлага зохион байгуулалтын онол, практикийн асуудлыг Марксист Ленинист онол арга зүйтэй холбосон судалгааны ажлыг

⁷ Социалист аж төрөх ёсны онол практикийн асуудал, Хурлын эмхтгэл, УХГ, Улаанбаатар, 1978

өргөн явуулж, эрдмийн зэрэг цол хамгаалуулах шаардлагатай буйг дурдсан бөгөөд, үүний дараагаар Монголд, ЗХУ (Зөвлөлт Холбоот улс)-д дээрх сэдвийн хүрээнд эрдмийн зэрэг цол хамгаалах ажил 1980-иад оны сүүлч хүртэл идэвхжиж, олон дэд эрдэмтэнгүүд төрж, тэдний олон арван бүтээлүүд социалист байгуулалтын зүй тогтол, шинж чанар, коммунист хүмүүжил, хүмүүсийн ахуй ухамсрын тухай ойлголт, мэдлэгийг тодруулан судалжээ.

Намын үзэл суртал, ухуулгын ажил нь эдийн засгийн харилцаанд социалист өмчийн давамгайлал нэмэгдэх тусам, түүний үйл ажиллагааны зохион байгуулалт, онолын үндэс, арга зүй, зарчим, сургалт, судалгааны ажил нь захиргаадах аргатай нягт хослон эрчимтэй явагдах болжээ. Намын үзэл суртлын ажлыг аж ахуй, нийгэм, соёл, боловсролыг хөгжүүлэх зорилт, түүнийг шийдвэрлэх арга зам, үйл явцтай нягт холбож, хүмүүсийн ухамсар дахь хуучин нийгмийн болон шарын шашны үзэл суртлын үлдэгдлийг эсрэг тэмцэх, хөдөлмөрчдийн эх оронч, интернационалч үзлээр хүмүүжүүлэх, тэдний улс төр, хөдөлмөрийн идэвхийг өрнүүлэхэд чиглүүлж байв. Тиймээс л зарим ном бүтээлд үзэл суртал, соёл, боловсролын хөгжлийн асуудлыг хольж хутгах, ялган харах асуудлыг орхигдуулах, бүрхэгдүүлэх, тойрч гарах явдал одоо ч байсаар байна.

1924 оны Үндсэн хуулийн *Нэгдүгээр бүлгийн гуравдугаар зүйлийн 1-д* “БНМАУ-ын хязгаарын дотор бүхий газар ба уурхай хийгээд ой мод, ус ба мөн тэдгээрийн баялгууд бол эрт цагаас нааш ард нийтийн хөрөнгө байсаар ирсэн зан суртал нь чухам одоогийн ард ёсонд нийлэлцэх тул энэхүү хөрөнгө бүрнээ ардын мэдэлд байвал зохих бөгөөд энэ тухай хувийн өмч байгуулж үл болно хэмээн заасан байна. Энд буй “эрт цагаас нааш ард нийтийн хөрөнгө байсаар ирсэн зан суртал нь чухам одоогийн ёсонд нийлэлцэх тул” гэсэн өгүүлбэр нь дээр өгүүлсэн эзэрхэг хөрөнгөтнийг төрүүлэн гаргадаг гол үндэс нь газрыг хувьдаа өмчлөх явдал бөгөөд (Зөвлөлийн засагт оронд газрыг улсын болгох процесс Монголд газрыг улсын болгосон шиг амар хялбар явагдаагүй-Б.П) ийм зан суртал манайд байгаагүй хэмээсэн ойлголт юм. Учир нь нүүдлийн мал аж ахуйг олон мянган жилийн туршид эрхлэн амьдарч ирсэн монголчууд малыг хувьдаа өмчилж, бэлчээрийг нийтээрээ ашиглаж ирсэн зан сурталтай байв. Гэхдээ газрыг өмч байгаагүй гэсэн хэрэг биш юм. Монголчуудын хувьд мал сүрэг амь амьдралын амин зуулга, үндсэн гол баялаг байв.

Мөн дээрх зүйлийн “хувийн өмч байгуулж үл болно” хэмээсэн заалт нь “БНМАУ-ын хязгаарын дотор бүхий газар ба уурхай хийгээд ой мод, ус ба мөн тэдгээрийн баялгууд”-д хамаарах бөгөөд малыг өмчлөх тухай асуудалд хамаарахгүй юм. Өөрөөр хэлбэл анхдугаар

Үндсэн хуульд ардын аж ахуйтны мал өмчлөх эрхийн тухай асуудлыг хөндөөгүй байна.

9 дүгээр зүйлд “ Жинхэнэ олон ардын аливаа эвлэл, хоршоо зэргийг байгуулах эрх чөлөөг хүндэтгэж, эл явдалд тус улсаас элдэв тусламж үзүүлбэл зохино. Энд хоршооллын өмчийн хэлбэрийг хүлээн зөвшөөрч, бүх талаар тусалж дэмжих санааг тусгажээ. Дээрх агуулгыг багтаасан анхдугаар Үндсэн хуулийн заалтууд нь БНМАУ-ын эдийн харилцаанд өмчийн олон хэлбэрийг хүлээн зөвшөөрч байна.

Анхдугаар Үндсэн хуульд БНМАУ-ын эдийн засгийн хэрхэн удирдан чиглүүлэх тухайд Улсын дээд эрхийн барих газрын тухай хоёрдугаар бүлгийн 29 дүгээр зүйлд: Тус улсын аливаа аж ахуй, эдийн засгийн бодлогыг ерөнхийлөн эрхлүүлэхийн тухай Засгийн Газрын дэргэд тусгай дүрмийн ёсоор Эдийн Засгийн Зөвлөлийг байгуулбал зохино хэмээн заажээ. Мөн бүлгийн зүйл 5 дугаар зүйлийн 5-д, тус улсын ард олны аж үйлдвэрийн бодлогыг зохиох, концесс ба монополь хэмээх онц эрхийг олгох, өөрчлөх, 6-д, аливаа зам тээвэр, цахилгаан мэдээ, шуудангийн явдлыг байгуулах, 8-д, улсын орлого зарлагыг батлах, гувчуур татварын зэрэг орлогын зүйлийг тогтоох, 9-д, улсын мөнгөний үнийг хэмжээг тогтоох, мөнгөний тэмдэгт цаас зоос үйлдүүлэх, 10-д, газар эдлэх нийтийн дүрмийг батлах, аймаг хошуудын нутгийн хил хязгаарыг байгуулах, дэлхийн баялгийг ашиглах дүрэм заавар тогтоох, 14-д, аливаа хэмжээ, жинлүүрийг тогтоох, 15-д, улсын аливаа тоо бүртгэх явдлыг тогтоох хэмээн тус улсад хөгжүүлэх эдийн засгийн салбар, чиглэлийг тодруулан заажээ.

1940 онд батлагдсан Үндсэн хууль нь “Нийгэм журамд давшин орохын учир улс орноо хөрөнгөтний бус замаар хөгжүүлэх явдлыг хангаж” хэмээн томьёолсон нь тодорхой хугацаанд эдийн засаг дахь өмчийн олон хэлбэрийг хүлээн зөвшөөрсөн хэдий ч улс, хоршооллын өмчийн давамгайлал цаашид өсөн нэмэгдэх эрх зүйн баталгаа болжээ

Эдийн засгийн харилцааны үндэс болох өмчийн хэлбэрийн тухайд 1924 оны Үндсэн хуулийн нэгэн адил газар шороо түүний хөрсөн доорх зүйл, ой мод, ус ба тэдгээрийн баялаг улсын өмч буюу нийт ардын хөрөнгө мөн болно. Эдгээрийг өмчийн хөрөнгө болгож үл болно хэмээн заажээ. Мөн 1940 оны Үндсэн хуулийн дээрх зүйлд, газар түүний баялгаас гадна фабрик, завод, төмөрлөгийн уурхай, алт боловсруулах явдал, төмөр, авто тээврийн зам, усан ба агаарын тээвэр, холбоо харилцааны хэрэгсэл, банк, машинаар өвс хадах станц, улсын аж ахуйнууд нь улсын өмч болохыг тэмдэглэн заасан байна.

1940 оны Үндсэн хуулийн Нийгмийн байгуулалт нэгдүгээр бүлгийн 6 дугаар зүйлд: Ард иргэнээс мал ба хөдөө аж ахуйн багаж зэвсэг хийгээд үйлдвэрлэлийн бусад багаж зэвсэг, түүхий эд мөн

боловсруулсан үйлдэхүүн, орон сууц, хашаа, барилга, гэр хогшил, орлого зэргийг өмчлөх эрх ба түүнчлэн хувийн өмчийг өвлөх эрхийг хуулиар хамгаална⁸ хэмээн заажээ.

Мөн нэгдүгээр бүлгийн 7 дугаар зүйлд: Хоршооллын байгууллагууд ба ардын нэгдлүүдийн нийгмийн газрууд нь бүх тоноглол, багаж хэрэгсэл, тэдгээрийн үйлдэж байгаа үйлдэхүүн, түүнчлэн сайн дураар нэгдсэн хөрөнгө хогшил, мал ХАА-н багаж, зэвсэг, нийтийн барилгуудын хамтаар эдгээр хоршоолсон байгууллагууд ба ардын нэгдлүүдийн нийгмийн өмч болно хэмээн заажээ. Эдгээр заалтуудаас харвал, БНМАУ-ын эдийн засагт өмчийн олон хэлбэрийг (улсын өмч, хоршооллын өмч, ардын аж ахуйтан-хувийн өмчийг) 1924 оны үндсэн хуулийн нэгэн адил хүлээн зөвшөөрчээ.

1940 оны БНМАУ-ын Үндсэн хууль тус улсын эдийн засгийг төлөвлөгөөтэй удирдах, чиглүүлэх асуудлыг анх удаа тодруулан тусгажээ. Уг хуулийн “Нийгмийн байгуулалт” нэгдүгээр бүлгийн 4 дүгээр зүйлд ... БНМАУ-ын аж ахуй, соёл, боловсрол болон улс нийтийн аж байдлыг өөрчлөн зохиох төлөвлөгөөг биелүүлэх явдлаар хангагдах үүнд:

- хөдөлмөрчин ардын аж ахуйг бүхий л аргаар хөгжүүлэн сайжруулахад улсаас тэтгэх

- хөдөлмөрчин ардуудын сайн дурын хамтарсан нэгдлүүдэд улсаас туслах хэмээн хэрхэн дэмжиж хөгжүүлэх аргыг тун тодорхой заасан байна. Мөн Улсын байгуулалт хоёрдугаар бүлэгт 10 дугаар зүйлд: Засгийн дээд эрх барих улсын захиргааны дээд газруудын эрхлэх хэргийг заасны 11-д Улс ардын аж ахуйн төлөвлөгөөг батлах хэмээн зааж өгчээ.

1940 оны Үндсэн хуульд БНМАУ-д хөгжүүлэх эдийн засгийн салбаруудыг Нийгмийн байгуулалт нэгдүгээр бүлгийн 4 дүгээр зүйлд:

- машинаар өвс хадах морин станцуудыг хөгжүүлэх,
- тус улсын дотор мал аж ахуй,
- аж үйлдвэр,
- харилцаа холбоо,
- тээврийг хөгжүүлэх явдлаар хангагдана хэмээн тодорхой зааж өгчээ.

Мөн Улсын байгуулалт хоёрдугаар бүлэгт 10 дугаар зүйлд: Засгийн дээд эрх барих улсын захиргааны дээд газруудын эрхлэх хэргийг зааж өгсний 12-д. Мөнгө ба зээлийн явдлыг удирдах, улсын орлого зарлагын төсвийг батлах, албан татвар хийгээд орлогыг тогтоох, 13-д. Улсын банк, аж үйлдвэр, хөдөө аж ахуй, худалдааны

⁸ 1924, 1940, 1960, 1992 оны Үндсэн хуулиуд, Улаанбаатар, 2007, 25 дахь тал

газар, албан байгууллагуудыг захирах, 17-д. Улсын байгалийн баялгийг хамгаалах ба ашиглах, газар шороо, ой мод ус бэлчээр ба түүний баялгийг ашиглах журмыг тогтоох, 18-д. Мал аж ахуй ба газар тариаланг хөгжүүлэх ажлыг зохион байгуулж удирдах, 19-д. Жин хэмжүүр тогтоох, 20-д. Улсын тоо бүртгэл тайланг зохион байгуулах, 21-д. Улсын орон сууц ба нийлсэн аж ахуй болон барилга хийгээд хотын байдлыг сайжруулах зам барилгыг удирдах хэмээн заж өгчээ.

1940 оны Үндсэн хуулийн 31 дүгээр зүйлд БНМАУ-ын Сайд нарын Зөвлөлийн удирдан эрхлэх үйл ажиллагааг зааж өгсний 2-д. Ардын аж ахуйн төлөвлөгөө ба улсын ба орон нутгийн орлого, зарлагын төсвийг биелүүлэх хийгээд албан татвар, зээллэгийн явдлыг биелүүлэх тухай арга хэмжээнүүдийг гүйцэтгэнэ хэмээн заажээ. Мөн дээрх зүйлийн 8-д. Хэрэг тохиолдвол БНМАУ-ын Сайд нарын Зөвлөлийн дэргэд соёл, боловсрол, аж ахуйн ажил явууллагыг эрхлэх төв газруудыг байгуулна хэмээн тус улсад өргөжин тэлж буй аж ахуй, соёл, үйлдвэрлэлийн үйл явцыг удирдлагаар ханган ажиллахыг заажээ.

1940 оны Үндсэн хуулийн 34 дүгээр зүйлд БНМАУ-ын СнЗ-д шууд захирагдах газруудыг 1. Төлөвлөгөө ба тоо бүртгэл, хянан шалгах газар, 2. Харилцаа холбооны ерөнхий хороо, 3. Уран сайхны хүрээлэн, 4 Шинжлэх ухааны хүрээлэн, 5. Улсын хэвлэлийн хүрээлэн гэсэн газруудыг нэрлэсэн байна.

БНМАУ-ын 1940 оны Үндсэн хуулийг 15 гаруй удаа өөрчилсөн бөгөөд анхны шинэчлэлт буюу БНМАУ-ын 24 дүгээр Бага Хурал 1941 оны 2 дугаар сарын 14-ны өдөр “БНМАУ-ын Үндсэн хуулийн 11 ба 34 дүгээр зүйлүүдийг өөрчлөх тухай” №24 тоот тогтоолыг гаргажээ. Үүнд, 2. Гар үйлдвэрийн холбоо нь үйлдвэр барилгын яамнаас тусгаарлаж улсын Гар үйлдвэрийн хоршооллын төв зөвлөлийг зохион байгуулж СнЗ-д шууд захирагдах учир БНМАУ-ын Үндсэн Хуулийн 34 дүгээр зүйлд дор заасан зүйлийг хэмээн оруулсугай хэмээн заажээ⁹. Энэ нь тус улсын аж ахуй, эдийн засгийн харилцаанд хоршооллын өмчийн үйлдвэрлэлийн эзлэх хувь жин өсөн нэмэгдэж байсантай холбоотой, нөгөө талаар БНМАУ-ын эдийн засагт хоршооллын өмчийн хэлбэрийг анх удаа Үндсэн хуульд тодорхойлон тусгажээ.

Дайны дараагаас БНМАУ-ын УААА, соёлыг төлөвлөгөөтэйгөөр удирдах ажил өрнөж, 1948-1952 онд анхдугаар таван жилийн төлөвлөгөө, 1953-1957 онд хоёрдугаар таван жилийн төлөвлөгөө хэрэгжүүлэн аж үйлдвэр, зам тээвэр, соёл, боловсролыг хөгжүүлэх зорилтыг биелүүлэн, тус улсын эдийн засагт улсын өмчийн үйлдвэр аж ахуйн газруудын тоо, эзлэх хувь жин өсөн нэмэгдсэн боловч

⁹ 1924, 1940, 1960 оны Үндсэн хуулиуд, Улаанбаатар, 2007, 54 дэх тал

хувийн өмч бүхий ардын аж ахуйтан, хоршооллын өмчийн систем хамт оршсоор байв. Энэ байдал МАХН-ын XII их хурлаас дэвшүүлсэн социализмыг дэлгэрэнгүй байгуулах буюу “Социализмын материал техникийн бааз”-ыг байгуулах ялангуяа ХАА-г хөгжүүлэх, шинжлэх ухааны техникийн ололтыг нэвтрүүлэх, улмаар орчин үеийн аж үйлдвэрийг 1940 оны Үндсэн хуульд зааснаар төлөвлөгөөтэй хөгжүүлэн, тавьсан зорилтыг биелүүлэх боломжийг бүрэн дүүрэн хангахгүй байв. Энэ нь УААА соёлыг хөгжүүлэх I, II таван жилийн төлөвлөгөөний мал аж ахуйг хөгжүүлэх талаар тавьсан зорилтууд бүрэн хэрэгжихгүй байснаар тайлбарлагдаж байв.

Ардын төрөөс улсын болон хоршооллын өмчийг өсөн нэмэгдүүлэх, хамгаалах чиглэлд анхаарч тогтоол, шийдвэр гаргаж байв. Бүр 1922 онд Ардын Засгийн Газрын дэргэд шинээр үүсэн төлжиж буй улсын эд хөрөнгийг хамгаалах, өсгөн үржүүлэх явдлыг хангах зорилго бүхий Хянан байцаах комиссыг байгуулж, анхдугаар Үндсэн хуульд Сайд нарын Зөвлөлийн шууд харьяанд байх байгууллага болгожээ. Улмаар 1925 оны эцсээр хянан байцаах яам болгон өөрчилж байв.

БНМАУ-ын анхны эрүү, эрүүгийн байцаан шийтгэх хууль “БНМАУ-ын шүүх цаазын бичиг”-ийн тусгай ангийн 43 дугаар зүйлд аливаа албан газрын санхүүд санаатайгаар гэм хор хийгчдийг улс төрд тэрсэлсэн онц аюултай гэм хэрэгт тооцохоор заажээ. Үүнээс хойш тус улсын Засгийн газраас улс, хоршооллын өмчийг хамгаалахад чиглэсэн тогтоол, шийдвэрүүд олноор гарах болжээ.

Тухайлбал, 1942 оны 1 дүгээр сарын 30-нд БНМАУ-ын Бага Хурлын Тэргүүлэгчдийн 5 дугаар хурлаар “Үйлдвэрийн газруудаас багаж хэрэгслийг ашиглаж хэрэглэх ба арчлан хамгаалах хийгээд мөнхүү үйлдвэрийн газруудаас боловсруулан гаргасан үйлдэхүүнийг тусгай хувиар баталгаагүйгээр гадагш худалдах явдлыг зогсоох тухай” тогтоолыг, 1947 онд БНМАУ-ын Бага хурлын тэргүүлэгчдийн 5 дугаар хурлаар “Улсын ба олон нийтийн хоршооллын байгууллагуудын өмчийг хамгаалах тухай”¹⁰ зэрэг олон тогтоолуудыг гаргаж байв.

БНМАУ-ын төр зөвхөн улс, хоршооллын өмчийг хамгаалах, өсгөх, арвилан хэмнэх асуудалд анхаарал хандуулаад зогсоогүй, ардын аж ахуйтны хувийн өмчийг хулгайлах асуудлыг зогсоох, сэргийлэх талаар ч тогтол шийдвэр гаргаж байв. Жишээ нь 1956 онд “Ард иргэдийн өмчийг хулгайгаас хамгаалах явдлыг чангатгах тухай” БНМАУ-ын АИХ-ын Тэргүүлэгчдийн зарлиг гарч байжээ¹¹.

¹⁰ Монголыг хууль тогтоомжийн түүхэн эмхтгэл. Боть IV. 1937-1958 он X сар. УБ.,2010.т.205, 304

¹¹ Монголыг хууль тогтоомжийн түүхэн эмхтгэл. Боть IV. 1937-1958 он X сар. УБ.,2010.т.525

Түүнчлэн 1957 оны 7 дугаар сарын 6-ны өдөр БНМАУ-ын АИХ-ын Тэргүүлэгчдийн “БНМАУ-ын Үндсэн хуулийн зарим зүйлийг өөрчлөх тухай” №104 зарлиг гарч, 5 дугаар зүйлийн “...улсын өмч буюу нийт ардын хөрөнгө мөн болно” гэснийг “... улсын өмч буюу нийтийн хөрөнгө мөн”, 7 зүйлд байсан “...эдгээр хоршоолсон байгууллагууд ба ардын нэгдлүүдийн нийгмийн өмч болно” гэснийг “...эдгээр нь хоршооллын байгууллага, хөдөө аж ахуйн нэгдлийн нийтийн өмч мөн”¹² хэмээн засаж найруулжээ.

УААА, соёлыг хөгжүүлэх таван жилийн төлөвлөгөөг түр завсарлан 1958-1960 онд УААА, соёлыг хөгжүүлэх гурван жилийн төлөвлөгөөг хэрэгжүүлжээ. Гурван жилийн төлөвлөгөөний зорилт нь тус улсын эдийн засагт социалист өмчийн харилцааг бүрэн ялуулах тодорхой зорилт дэвшүүлсэн хөтөлбөрүүдээс бүрдэж, амжилттай хэрэгжсэн байна¹³.

Гурван жилийн төлөвлөгөөний дараа социалист өмчийн харилцаа тус улсын ХАА-н салбарт ялжээ. 1957 оны байдлаар нийт мал сүргийн (23 сая) 1.4 хувь САА-д, 0.9 хувь нь МААМС-д, 22.4 хувь ХААН-д, 17.8 хувь нь ХААН-ийн гишүүдийн амины аж ахуйд, 57.5 хувь нь ард, ажилчин, албан хаагчдын аж ахуйд ногдож байв¹⁴. Харин гурван жилийн төлөвлөгөөний сүүлийн жил буюу 1960 онд улсын хэмжээгээр нийт 23,5 сая байсны дийлэнх буюу 73.8 хувь хоршооллын өмчийн ХААН-д, 22 хувь нэгдлийн гишүүдийн амины аж ахуйд, 2.1 хувь нь улсын өмчийн САА-д, мөн 0.7 хувь улсын өмчийн МААМС-д харьяалагдах болжээ¹⁵.

ХАА-н салбарт социалист өмчийн харилцааг бүрэн ялуулах асуудал зөвхөн малыг нийгэмчлэхээр хязгаарлагдахгүй бөгөөд энэ нь тариалангийн үйлдвэрлэлд (хэдийгээр газар улсын өмч хэдий ч) мөн хамрагдаж байв. 1957 оны байдлаар улсын нийт тариалангийн талбайн 64.9 хувь нь улсын өмчийн аж ахуйд, 13.7 хувь хоршооллын өмчийн аж ахуйд, 21.4 хувь хувийн аж ахуйтанд харьяалагдаж байсан¹⁶бол, гурван жилийн төлөвлөгөөний хүрээнд улс орон даяар өрнөсөн атар газар эзэмших кампанит ажлыг өрнүүлэн газар тариалангийн үйлдвэрлэлд эзлэх улс, хоршооллын өмчийн эзлэх жинг нэмэгдүүлснээр 1960 оны байдлаар улсын нийт тариалангийн талбайн 77.5 хувь нь улсын өмчийн САА-д, 22.5 хувь нь хоршооллын өмчийн

¹² 1924, 1940, 1960 оны Үндсэн хуулиуд. УБ., 2007. т.73

¹³ БНМАУ-ын нийгэм, эдийн засгийн ололт: Туршлага, сургамж (1954-1980-аад оны сүүлч) Ред. Г.Чулуунбаатар. УБ., 2022. т.14

¹⁴ БНМАУ-ын УААА 1962 онд. Статистикийн эмхэтгэл. УБ., 1963. т.32

¹⁵ БНМАУ-ын УААА 40 жилд. Статистик эмхэтгэл. УБ., 1961. т.46

¹⁶ Б.Пунсалдулам. Монголын газар тариалангийн түүх (1900-1958 он). Тэргүүн дэвтэр. УБ., 2017. т.154

ХААН-д харьяалагдах болжээ¹⁷. Мөн энэ гурван жилийн хугацаанд эд хэрэглэгчдийн хоршоог татан буулгаж, улсын худалдааны системд бүрэн шилжүүлжээ.

БНМАУ-ын аж үйлдвэрийн салбарт улсын өмч зонхилж байсан хэдий ч үйлдвэрлэлийн хоршооллын артелиуд үйл ажиллагаа идэвхтэй явуулж (1940 оны Үндсэн хуульд 1941 онд өөрчлөлт оруулсныг дээр дурдсан Б.П) байв. Гурван жилийн төлөвлөгөө хэрэгжиж дууссаны дараа жил буюу 1961 онд хоршооллын өмчийн аж ахуй нэгжийн тоо 65 болж, аж үйлдвэрийн нийт бүтээгдэхүүний 17.3 хувийг үйлдвэрлэж байв¹⁸.

Тус улсын аж үйлдвэрийн салбарт хоршооллын өмчийн аж ахуйн нэгжүүд 1972 оны БНМАУ-ын СнЗ-ийн “Үйлдвэрийн нэгдэл байгуулах тухай” тогтоол гарах хүртэл үйл ажиллагаагаа эрхэлсээр байв. 1971 оны 12 дугаар сард хуралдсан үйлдвэр, хоршооллын VIII их хурлаас үйлчилгээг сайжруулах, үйлдвэрлэлийн үр ашгийг дээшлүүлэх зорилгоор үйлдвэр, хоршооллын аж үйлдвэрийн ба аж ахуйн газруудыг улсын мэдэлд шилжүүлэх нь зүйтэй хэмээн үзсэнээр, БНМАУ-ын СнЗ-ийн 1972 оны 4 дүгээр сарын 28-ны өдрийн “Үйлдвэрүүдийн нэгдэл байгуулах тухай” №158 тоот тогтоол гарч гутал, арьс, шир, оёдол, ноос боловсруулах болон нэхмэлийн чиглэлийн ижил төрлийн үйлдвэрүүдийг нэгтгэн удирдах нэгдлийг Хөнгөн ба Хүнсний Үйлдвэрийн яамны харьяанд 1972 оны 7 дугаар сарын 1-нээс эхлэн байгуулж, тэдгээрийг аж ахуйн тооцооны үндсэн дээр ажиллахаар тогтоожээ. Энэ тогтоолыг 1975 оны БНМАУ-ын СнЗ-ийн 361 дүгээр тогтоолоор өөрчлөн, 1. Арьс ширний үйлдвэрийн нэгдэл, 2. Ноосны үйлдвэрийн нэгдэл, 3. Оёдлын үйлдвэрийн нэгдэл болгон байгуулж, түүний захиргаа, аж ахуйн зардлыг харьяа үйлдвэрүүдийн ашиг, ашигт ажиллагааны түвшнээс тогтоосон шимтгэлээр санхүүжж байхаар тогтоожээ¹⁹. Үйлдвэрүүдийн нэгдэл байгуулагдсанаар Аж үйлдвэрийн комбинатын захиргааг 1972 оны 7 сарын 1-нээс татан буулгажээ. Энэ арга хэмжээний үр дүнд аж үйлдвэрийн салбарт эзлэх улсын өмчийн эзлэх хувь 97-98-д хүрчээ.

1960 оны Үндсэн хуулиас хойш социалист өмчийг хамгаалах, арвилан хэмнэх талаар олон тогтоол, шийдвэр гарч, “Социалист өмчийн талаар гарсан хууль тогтоомжийн эмхтгэл”-ийг хоёр ботиор хэвлэн гаргажээ²⁰.

1960 оны БНМАУ-ын Үндсэн хуулийн оршилд, БНМАУ бол

¹⁷ БНМАУ-ын УААА 40 жилд. Статистик эмхэтгэл. УБ., 1961. т. 60, 83

¹⁸ БНМАУ-ын УААА 1962 онд. Статистикийн эмхэтгэл. УБ., 1963. т. 66, 76

¹⁹ Аж үйлдвэрийн талаар гаргасан хуульчилсан актуудын системчилсэн эмхэтгэл. II боть (1961-1975) Эмхэтгэсэн Д. Ёндон. УБ., 1978. т. 42

²⁰ Социалист өмчийн талаар гарсан хууль тогтоомжийн эмхтгэл. Боть I, II УБ., 1980

В.И.Лениний сургаалыг мөрдлөг болгон феодализмаас капиталист хөгжлийн шатыг алгасаж социализмд шилжих замдаа, нийгэм, эдийн засгийн хувьсгалт их үндсэн өөрчлөлт хийж социалист шинэ эдийн засгийг байгуулж, социалист үйлдвэрлэлийн харилцааг бүх УААА-д ялуулж, хөдөлмөрчин ард түмний аж амьдрал соёлын хэмжээг дээшлүүлэх талаар түүхэн их амжилт олов хэмээн тэмдэглэжээ.

БНМАУ-ын зорилго бол социализмыг төгөлдөр байгуулж, цаашдаа коммунист нийгэм байгуулах явдал мөн. Үндсэн хуулийн 15 дугаар зүйлд “Төрийн эдийн засгийн бодлого нь улс ардын аж ахуйн төлөвлөгөөнд социализмын эдийн засгийн хуулийн шаардлагыг зөв тусгахад чиглэгдэнэ” хэмээн заасан байна.

БНМАУ-ын социалист үйлдвэрлэлийн үндсийг Төрийн эдийн засгийн үндсэн зарчим ба үүрэг хоёрдугаар бүлгийн 8-р зүйлд: ...үйлдвэрлэлийн хэрэгслийг хувьдаа өмчлөх журмыг халж, хүн хүнээ мөлжих ёсыг устгасны үрээр тогтсон социалист системийн аж ахуй, үйлдвэрлэлийн хэрэгслийг өмчлөх социалист өмч мөн. 9-р зүйлд, БНМАУ-ын социалист өмч бол улсын (бүх ард түмний хөрөнгө), хоршооллын (хөдөө аж ахуйн нэгдэл ба бусад төрлийн хоршооллын хөрөнгө) ийм хоёр хэлбэртэй байна.

11-р зүйлд, ... ХААН-н өрх нэг бүр нэгдлийн нийгмийн үйлдвэрлэлд гишүүдээ оролцуулж үндсэн орлогоо олохоос гадна амины туслах аж ахуйтай байж болно. 13-р зүйлд, Иргэний хөдөлмөрлөж олсон орлого, хадгаламж, орон сууц, амины туслах аж ахуй, амины хэрэгцээт зүйлс, гэрийн эд хогшлыг аминдаа өмчлөх эрх, түүнчлэн амины өмчийг өвлөх эрхийг хуулиар хамгаална. Амины өмчийн эрхийг улс нийгмийн эрх ашигт харш ашиглаж үл болно хэмээн заасан нь өмнөх 1924, 1940 оны Үндсэн хуулиудаас зарчмын том ялгаатай болжээ.

1960 оны Үндсэн хуулийн 16 дугаар зүйлд “Улсын санхүүгийн төлөвлөгөөг улс ардын аж ахуйг хөгжүүлэх төлөвлөгөөнд зохицуулан улсын төсөв болгож хуульчлан баталж нийтэлнэ” хэмээн заажээ. 1960 оны Үндсэн хуулийн дагуу БНМАУ-д өрнөсөн УААА, соёлыг хөгжүүлэх III-VIII таван жилийн төлөвлөгөөг төвлөрсөн төлөвлөгөөт таван жил хэмээн үзнэ.

II. Дүгнэлт

Эцэст нь нэгтгэн үзвэл, Нэгд, БНМАУ-ын 1924, 1940 оны Үндсэн хуульд тус улсын эдийн засагт үйлчилж байсан өмчийн олон хэлбэрийн харилцааг үгүйсгээгүй байна. Харин 1960 оны Үндсэн хуульд БНМАУ-ын эдийн эдийн үндэс нь социалист өмч (улсын, хоршооллын, амины) мөн зааж өгчээ.

Хоёрт, 1940 оны Үндсэн хуульд БНМАУ-ын аж ахуй, соёлыг төлөвлөгөөгөөр удирдан явуулах тухай заасан бол, 1960 оны Үндсэн хуульд УААА, соёлыг төлөвлөгөөгөөр хөгжүүлэхийг хуульчлан баталжээ.

Гуравт, 1960 оны Үндсэн хууль батлагдсанаас хойших УААА, соёлыг хөгжүүлэх таван жилийн (III-VIII) төлөвлөгөөт хөгжлийг төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засгийн хөгжил хэмээн нэрлэж, өмнөх таван жилийн төлөвлөгөөт (I,II) хөгжлийн үеэс ялган салгаж ойлгох нь зүйтэй байна.

Дөрөвт, БНМАУ-ын Үндсэн хуульд түүхэн хөгжлийн цаг үед тус улсад орчин цагийн хөдөө аж ахуй, аж үйлдвэрийг төлөвлөгөөтэй удирдан чиглүүлж хөгжүүлснээр нүүдлийн мал аж ахуйн орноос хөдөө аж ахуй-аж үйлдвэрийн орон болон хувирч, эдийн засгийн хөгжлийн шинэ шатад гарчээ.

[Ном зүй]

- 1924,1940,1960,1992 оны Үндсэн хуулиуд, Улаанбаатар, 2007
- БНМАУ-ын нийгэм, эдийн засгийн ололт: Туршлага, сургамж (1954-1980-аад оны сүүлч), Ред. Г.Чулуунбаатар, Улаанбаатар, 2022
- БНМАУ-ын УААА 40 жилд, Статистик эмхэтгэл, Улаанбаатар, 1961
- БНМАУ-ын УААА 1962 онд, Статистикийн эмхэтгэл, Улаанбаатар, 1963
- И.М.Майский, Орчин үеийн Монгол, Улаанбаатар, 1999
- Монголын хууль тогтоомжийн түүхэн эмхтгэл, Хоёрдугаар боть 1911-1926, V сар, Улаанбаатар, 2010
- Монголыг хууль тогтоомжийн түүхэн эмхтгэл Боть IV 1937-1958, X сар, Улаанбаатар, 2010
- Монголын нийгэм-улс төрийн сэтгэлгээнийн түүхийн асуудал (Философийн ухааны доктор, профессор Дуламын Дашжамцын мэндэлсний 85 жилийн ойд зориулав), Улаанбаатар, 2015
- Ч. Нямбуу, БНМАУ-ын хүн амын нөхөн үйлдвэрлэл, Улаанбаатар, 1967
- Б.Пунсалдулам, Монголын газар тариалангийн түүх (1900-1958), Тэргүүн дэвтэр, Улаанбаатар, 2017
- Социалист аж төрөх ёсны онол практикийн асуудал, Хурлын эмхтгэл, УХГ, Улаанбаатар, 1978.

[Abstract]

**Constitutions of The Mongolian People's Republic Ratified in
1924,1940 and 1960 as the Determiners of State Economy
Development and its Tendency**

Punsaldulam Bor

*Doctor of History (Sc.D.), Professor
Principal Researcher at the Institute of History
and Ethnology, Mongolian Academy of Sciences
Ulaanbaatar, Mongolia*

Being of Mongolians who had had pastoralism for thousands of years changed at the end of the XIX century and new economy styles were established. Mongolia included in the world market by its livestock, livestock raw materials and natural wealth making livestock breeders to be divided by their capital owning amount.

Camel caravan transportation, land and camel renting, hay making and usury had appeared among the Mongolians instead of their traditional pastoralism. People who developed these new economic forms had widened the market relations.

Mongolia that declared its state independence at the beginning of the XX century had policy to develop its homeland as the countries where modern culture, education, industry had been developed intensively admitted different property rights for the economy in their constitutions ratified in 1924 and 1940.

The constitution ratified in 1960 admitted the state and cooperation property rights in the economic relations and confirmed the jurisprudence base for the planned development of the state economy.

[Keywords]

Economy, New form, Plan, Management, Agriculture, Development.